



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/410

Ховд


Багц болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5/07 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.3-т тусгагдсан, Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн тохижилтын ажил 150 000 000 төгрөг (нэг зуун тавин сая төгрөг)-ийн өртөг бүхий төсөл арга хэмжээг дараах багц болгон хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсөвт өртөгт багтаан барилга угсралтын гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хариуцан ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан) - д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2073



Аймгийн захиралдагч 2022 оны  
06 дугаар сарын 29 ныгөдрийн  
А/410 дугаар захирамжийн хэвэралт

### Төсвийн задаргаа

- 1.Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн явган хүний замын ажил -51 542 531 төрөг
- 2.Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын хажуу талын тоглоомын талбайн тохижилтын ажил - 46 012 899 төгрөг
3. Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн, Хөшөө цогцолборын хажуу талын талбайн тохижилтын ажил - 44 332 207 төгрөг
4. Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн гэр өргөө болон бусад тохижилтын ажил - 8 122 589 төгрөг

-оОо-